



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 4/201

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 54 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, амралт, жуулчны газар, үзэсгэлэн худалдаа, хурим найр, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрагдсанаас хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдийг ПГУ шинжилгээний сөрөг хариу /72 цагийн хугацаанд хүчинтэй/ эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний сөрөг хариу /48 цагийн хугацаанд хүчинтэй/ үндэслэн нэвтрүүлж 7 хоног гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Онцгой комиссод үүрэг болгосугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд улсын чанартай автозам дагуух цайны газруудын үйл ажиллагааг хориглосугай.

481210547

5. Худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг хэвийн горимд шилжүүлж, архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ